

**ШИВЭЭ ГОВЬ СУМЫН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХООРОНДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

Сэвхүүл

Нэг талаас Шивээ говь сумын Засаг дарга, нөгөө талаас “Шивээ овоо” ХК хамтран ажиллах талаар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Үндсэн хууль бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон талуудын хамтын ажиллагаанд ил тод нээлттэй байх, үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандах зарчимд тулгуурлана.

1.2. Санамж бичгийн зорилго нь Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, иргэдэд хүрэх үйлчилгээний цар хүрээг өргөтгөж, нийтлэг эрх ашгийн төлөө хамтран ажиллахад оршино.

Хоёр: Сумын засаг даргын эрх, үүрэг

2.1. Засгийн газар, Яам, агентлагын түвшинд “Шивээ-Овоо” ХК-тай холбогдолтой асуудлыг уламжлан хамтран ажиллана.

2.2. “Шивээ-Овоо” ХК-ийн ажилтан албан хаагчдыг төрийн дээд шагналаар шагнуулахад бодлогоор дэмжиж ажиллана.

2.3. Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар аваагүй ажилтан албан хаагчдын газрын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

2.4. “Шивээ-Овоо” ХК-ийн ажилчдын орон сууц барихад бодлогоор дэмжин хамтран ажиллана.

2.5. “Шивээ-Овоо” ХК-ийн ажилтан албан хаагчдыг урьдчилан мэргийлэх үзлэг, шинжилгээнд хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулах ажлыг Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

Гурав: “Шивээ-Овоо” ХК-ийн эрх, үүрэг

3.1. Уурхайчдыг идэвхижүүлж, хандлага сэдлийг сайжруулах чиглэлээр нэр хүндтэй нийгмийн манлайлагч, зүтгэлтнүүдээр хийлгэж буй яриа таниулга, сургалтыг төлөвлөгөөний дагуу сумын ААНБайгууллага, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.

3.2. Сумын байгууллага аж ахуйн нэгжүүдэд бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, чадавхижуулах тал дээр хамтран ажиллана.

3.3. Орон нутгийн байгууллагуудтай харилцаа холбоогоо сайжруулж, итгэлцэл бий болгон ажиллана. /Сумын төр захиргааны байгууллага, иргэд, хэвлэл мэдээлэл, сургууль, эмнэлэг, ТББ, аж ахуйн нэгж/

3.4. Сумын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй нягт хамтран ажиллана.

3.5. Олон улсын OSHAS-18001 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлж ажиллана.

3.6. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, сайн чанарын нүүрс нийлүүлнэ.

Дөрөв: Хэрэгжилтийг тооцох нөхцөл

4.1. Санамж бичигт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

4.2. Санамж бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр хэлэлцэж дүгнэнэ.

4.3. Санамж бичгийг хоёр хувь бичгээр үйлдэж, талууд тус бүр нэг хувийг эзэмшинэ.

4.4. Санамж бичгийн агууллагад талууд харилцан тохиролцсоноор нэмэлт өөрчлөлт оруулж болно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАГ
Ц.ЭНХТҮВШИН
2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

ШИВЭЭ ГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.ГАНЧИМЭГ
2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр